**БАЯНТҮМЭН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН 6 ДУГААР АНГИЙН СУРАГЧДЫН МОНГОЛ ХЭЛ, БИЧГИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН СЭДЭВ**

ХУГАЦАА 60 МИНУТ НИЙТ ОНОО 20

**Эхийг уншаад даалгаврыг гүйцэтгээрэй.**

**“А” хувилбар**

**Маргааш өвгөн**

Эрт урьд цагт “Маргааш” гэдэг нэртэй өвгөн байжээ. Тэр багаасаа аваад юу л хийнэ “Маргаашаас эхэлнэ” гэсээр байгаад тоо томшгүй олон маргаашийг зүв зүгээр өнгөрүүлдэг байжээ. Далан нас хүртлээ юу ч хийж чадаагүй болохоор хүмүүс түүнд “Маргааш өвгөн” гэдэг хоч өгчээ.

Нэгэн өдөр өнөөх өвгөн мөнгөн цагаан сахлаа имрээд, цал буурал толгойгоо илж, уртаар санаа алдаад: “Толин дотор үзэхүйеэ толгойн үс минь цайж орхижээ. Тун ч цалгар явсаар далан насыг хэтэрч, тоогүй олон маргаашийг усны урсгал мэт өнгөрөөв” гэжээ.

Өвгөн залуу насандаа чармайж сурахгүйгээр маргаашийг хүлээсээр далан насыг хоосон өнгөрүүлсэн нь юутай харамсалтай аж.

**Ажиллах даалгавар:**

1. Хүүрнэсэн эхийн гол санааг тодорхойлж бичнэ үү? /2 оноо/
   …………………………………………………………………………………………
   …………………………………………………………………………………………
   ………………………………………………………………………………………..

2. **“**Нэгэн өдөр өнөөх өвгөн цал буурал толгойгоо илэв.” гэсэн өгүүлбэрээс цөм бүтцийг ялгаад, тодорхойлоорой.
   /2 оноо/

.......................................................................................................................
.......................................................................................................................
.......................................................................................................................

3. Эхийн гол санаанд тохирох хэлцийг сонгоорой. /2 оноо/
   А . Залхуугаас заяа зайлна. Б. Их залхуугаас бага залхуу
   В. Залхуу хүн цавагтаа хүрэхгүй болдог. Г. Залхуу хонинд өөрийнх нь ноос тээр

4. “ толгойгоо”-үгийг үгийн бүтцээр зөв задалсныг олж дугуйлна уу? /2 оноо/
   А. Толгой+гоо Б. Толгой+г+0+оо
   В. толгой+г+оо Г. толгой+ыг+оо

5. “ сахал+аа=? залгаж бичээд, зөв бичих дүрмийг тайлбарлана уу. /2 оноо/
   …………………………………………………………………………………………
   …………………………………………………………………………………………
   …………………………………………………………………………………………

6. Ч. Лодойдамба “Шаргачин” өгүүллэгт Шаргачин янзага руугаа очихгүй яагаад өргөн тал руу цойлдон давхив? Шаргачныг хөөх үед та нар хамт явсан бол юу гэж хэлэх байсан бэ? /5 оноо/

.........................................................................................................................

..........................................................................................................................................
..........................................................................................................................................
..........................................................................................................................................
..........................................................................................................................................
..........................................................................................................................................

7. Галигаас үндэсний бичигт хөрвүүлээрэй. /5 оноо/

А. Минү нэр-э Номин. Энэ ман-у мори.

б. Үгсийг уншаад цагийн утгатай үг аль нь вэ?

А. Б. В. Г.

в. Цэгийн оронд олон тооны дагавраас алийг нь сонгох вэ?

А. Б. В. Г.

г. Хатуу дэвсгэр гийгүүлэгчээр төгссөн үгэнд дагуулах нөхцөл аль нь вэ?

А. Б. В. Г.

д. 1-р биед хамаатуулах нөхцөлийг олоорой.

А. Б. В. Г.

Даалгавар гүйцэтгэсэн:............................................

**БАЯНТҮМЭН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН 6 ДУГААР АНГИЙН СУРАГЧДЫН МОНГОЛ ХЭЛ, БИЧГИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН СЭДЭВ**

ХУГАЦАА 60 МИНУТ　　　　　　　　　　　　　　　　　　НИЙТ ОНОО 20

**Эхийг уншаад даалгаврыг гүйцэтгээрэй.**

**“Б” хувилбар**

**Сарьсан багваахай**

Жигүүртэн, араатан хоёр хэрэлдэхэд сарьсан багваахай ямагт тэднээс хол зогсоно. Хэрэв жигүүртэн дийлвэл тэр жигүүртэн шувуудын сүрэгт нисэн ирж “Би угаасаа шувуу” гэдэг байжээ. Хэрэв араатан дийлвэл сарьсан багваахай араатны сүрэгт ирж “Би уулаасаа дөрвөн хөлтэй амьтан” гэдэг байжээ.

Гэтэл удалгүй араатан жигүүртэн хоёр найрамдахад бүгд түүнийг хөөжээ. Тэр цагаас хойш сарьсан багваахай ичээд өдөр нуугдаж, шөнө нисдэг болжээ.

Санаа муут яван хатна, сарьсан багваахай наранд хатна гэгчийн үлгэр энэ болой. Багваахай наранд хатдаг нь үнэн. Далавч нь үргэлж чийглэг байх шаардлагатай байдаг бөгөөд нар үзвэл хатсан навч шиг хунирчихна. Тийм учир шөнөөр гөрөөлдөг. Чөтгөр шулмын элч биш биз гэж бодогдмоор.

**Ажиллах даалгавар:**

1. Ххүрнэсэн эхийн гол санааг тодорхойлж бичнэ үү?　　　　　　　/2 оноо/
   …………………………………………………………………………………………
   …………………………………………………………………………………………
   ………………………………………………………………………………………..

2. **“**Гэтэл удалгүй араатан сарьсан багваахайг хайр найргүй хөөжээ” гэсэн өгүүлбэрээс цөм бүтцийг ялгаад, тодорхойлоорой.　　　　　/2 оноо/
   ………………………………………………………………………………………
   ………………………………………………………………………………………

3. Эхийн гол санаанд тохирох хэлцийг сонгоорой.　　　　　　　　/2 оноо/
   а. Сайн санааны үзүүрт тос　　　　Б. Улааныг үзэж урвах, шарыг үзэж шарвах
   В. Өглөөний инээд үдшийн ханиад　　　Г. Сохрын газар сохор, доголонгийн газар доголон.

4. “ шувуудын ”-үгийг үгийн бүтцээр зөв задалсныг олж дугуйлна уу?　　/2 оноо/
   А. Шувуу+д+0+ын　　　　　　　Б. Шувуу+дын
   В. шувуу+д+ын　　　　　　　　Г. шувууд+ын

5. “ шөнө+өөр=? залгаж бичээд, зөв бичих дүрмийг тайлбарлана уу.　　/2 оноо/
   .............................................................................................................................
   .............................................................................................................................

6. П. Хорлоо “Алт Мөнгө хоёр” өгүүллэгт: Дүрүүд хоорондоо зөрчилдсөн үү? Хэнд нь бэрхшээл учрав? Хэнд нь боломж гарсан бэ?　　　　　/5 оноо/
   ....................................................................................................................................
   ....................................................................................................................................
   ....................................................................................................................................
   ....................................................................................................................................
   ....................................................................................................................................
   ....................................................................................................................................
   ....................................................................................................................................

7. Даалгавар гүйцэтгээрэй.　　　　　　　　　　　　　　/5 оноо/

А. Галигаас үндэсний бичигт хөрвүүлээрэй.

Минү дэгүү Гэрэлм-а гэгүү-бэн сагаба.

Б. Үгсийг уншаад орны утгатай үгийг олоорой.

А. Б. В. Г.

В. Цэгийн оронд олон тооны дагавраас алийг нь сонгох вэ?

А. Б. В. Г.

Г.Зөөлөн дэвсгэр гийгүүлэгчээр төгссөн үгэнд дагуулах нөхцөл аль нь вэ?

А. Б. В. Г.

Д. 3-р биед хамаатуулах нөхцөлийг олоорой. /1 оноо/

А. Б. В. Г.

6а ангийн сурагч ......................................